

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХИАЛГААР ГАДААД УЛСЫН АКАДЕМИ, ИХ,
ДЭЭД СУРГУУЛИУДАД СУРАЛЦАЖ БУЙ АЛБА ХААГЧ, СУРАЛЦАГЧДЫН
ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТАЛААР**

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд суралцагчдыг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ын 5.2.1 “тухайн байгууллагын захиалгаар гадаадын академи, их, дээд сургуульд адъюнктур, магистр, бакалаврын зэргээр боловсрол эзэмших эрх авсан боловч төрийн сангийн зээлд хамрагдаж чадаагүй алба хаагчдад ажиллаж байсан үеийнх нь албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны нэмэгдлийг сар бүр олгоно”, 5.2.2 “ерөнхий боловсролын сургууль төгсөгч болон магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байгаад тухайн байгууллагын захиалгаар гадаадын академи, их дээд сургуулийн бакалаврын зэрэг олгох сургалтад элсэн суралцагчдад ТТ-3 ангиллын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэлэг, цолны нэмэгдлийг сар бүр олгоно” гэсний дагуу суралцагчдын цалинг олгож байна.

Гадаадын академи, их, дээд сургуульд суралцагчдын зардлын төсөв 2023 онд 677,8 сая төгрөг батлагдаж энэ оны 01 дүгээр улирлын байдлаар 189,2 сая төгрөг олгож, 488,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Гадаадын их, дээд сургуульд суралцагчдад олгосон зардлыг сүүлийн 3 жилээр харуулбал /сая төгрөг/:

Үзүүлэлт	2020 он		2021 он		2022 он		2023 оны 1-р улирал	
Цалин, цол	86	711,0	87	732,8	88	768,2	88	185,5
ЭМД а/о-с	86	14,2	87	14,7	88	11,5	88	3,7
Замын зардал	84	80,4	1	0,756	80	74,3		
Бүгд дүн /сая төг/		805,6		748,3		854,0		189,2

Суралцагч 1 алба хаагчид олгож буй тэтгэлгийн дүнг дунджаар харуулбал /төгрөг/:

Журмын заалт	ЗГ-ын 2019 оны 472 тогтоол				
	Цалин зэрэглэл	Тэтгэлэг /сар/	ЭМД а/о /сар/	Тэтгэлэг /жил/	ЭМД а/о /жил/
5.2.1.	ТТ-8-15	815.365	16.307	9.784.380	195.688
5.2.2.	ТТ-3	642.939	12.859	7.715.268	154.305

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР